



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/32

Булган сум

「Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг
чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулахыг Архивын тасгийн дарга (Ш.Болдбаатар)-д даалгасугай.

2. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1,431,000 (нэг сая дөрвөн зуун гучин нэгэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 12-ны/ний өдрийн 432 дүгээр
захирамжийн хавсралт

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН АЖИЛТНУУДЫН
НЭГДСЭН СУРГАЛТЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ	
				Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	2	3	4	5	6
1	Кофе	ш	240	500	120,000
2	Печень	ш	24	10,000	240,000
3	Нэг удаагийн аяга	ш	240	100	24,000
4	Нэг удаагийн халбага	уут	1	7000	7000
5	Бургер (2 өдөр)	ш	160	6500	1,040,000
Бүгд					1,431,000